



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 12

Сүхбаатар сум

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд
хийсэн 2, 3 дугаар улирлын дүнгийн тухай

Төсвийн тухай хуулийн 69.3, Монгол улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.7, Сангийн Сайдын 2019 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх хүрээний төсвийн байгууллага орон нутгийн өмчийн ААТҮГ-ын Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилтэд хийсэн 2024 оны 2, 3 дугаар улирлын аудитын нэгтгэл дүгнэлтийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудаас шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх хүлээсэн үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай дүгнэлт авсан эрх бүхий албан тушаалтнуудад Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д “Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.5-д “Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ.” гэсэн заалтуудыг тус тус үндэслэн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх хугацаатай албан шаардлага, болон хариуцлага тооцох үндэслэл бүрдэж байгаа тул цаашид төсвийн ил тод байдлыг хангах үүргээ хэрэгжүүлж ажиллахыг Төсвийн захирагч, ОНӨААТҮГ-ын захирлуудад даалгасугай.

Гурав. Дотоод аудитын хорооны тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нарийн бичгийн дарга (Т.Мөнхзул)-д үүрэг болгосугай.

4324003012

Хорооны дарга:



Л.Лхагвадорж
(Аймгийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга:



Т.Мөнхзул
(Ахлах дотоод аудитор)

Гишүүд:




Т.Одсүрэн
(Санхүүгийн хяналт, дотоод
аудитын албаны дарга)



Ө.Сувдаа
(Аймгийн Засаг даргын
Тамгын газрын дарга)



Х.Мөнхжаргал
(Санхүү төрийн сангийн
хэлтсийн дарга)



Б.Янжинлхам
(Хууль зүйн хэлтсийн дарга)



А.Дашбат
(Иргэний төлөөлөл)



А.Гэрэлмаа
(Иргэний төлөөлөл)

Дотоод аудитын хорооны 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 12 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА, ОНӨААТҮГ-ЫН ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН АУДИТЫН ДҮГНЭЛТ

Байгууллагын нэр	Мэдээлэл байршуулах байгууллагын тоо	Хэрэгжилтийн хувь /1-р улирал/	Хэрэгжилтийн хувь /2-р улирал/	Хэрэгжилтийн хувь /3-р улирал/	Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
Баруунбүрэн сумын дүн	5	58.1	61.5	60.1	Хангалтгүй	Орон нутгийн төсвийн болон өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулахад төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн.
Түшиг сумын дүн	5	59.0	57.0	71.4	Хангалтгүй	
Орхонтуул сумын дүн	6	91.0	73.7	79.5	Хангалтгүй	
Шаамар сумын дүн	6	61.4	64.3	79.8	Хангалтгүй	
Мандал сумын дүн	7	72.4	72.7	82.8	Сайжруулах шаардлагатай	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ил тод, нээлттэй байх хуулиар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, шилэн дансны мэдээлэл байршуулалтын сайжруулах шаардлагатай
Төсвийн ерөнхийлөн захирагч	8	80.1	82.4	84.3	Сайжруулах шаардлагатай	
ОНӨААТҮГ-ын дүн	23	93.0	86.7	93.5	Хангалттай	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ил тод байдлыг ханган ажилласан.
Орхон сумын дүн	5	95.0	74.2	93.6	Хангалттай	
Сайхан сумын дүн	7	71.8	93.7	95.5	Хангалттай	
Сант сумын дүн	5	75.7	66.9	95.6	Хангалттай	
Баянгол сумын дүн	5	72.5	93.8	96.1	Хангалттай	
Ерөө сумын дүн	6	94.8	97.6	96.4	Хангалттай	
Зүүнбүрэн сумын дүн	5	95.9	95.5	96.8	Хангалттай	
Хушаат сумын дүн	5	85.6	96.6	96.9	Хангалттай	
Хүдэр сумын дүн	5	58.1	85.7	97.4	Хангалттай	
Алтанбулаг сумын дүн	5	80.2	97.7	98.0	Хангалттай	
Ойн ангийн дүн	5	94.2	97.7	98.2	Хангалттай	
Сүхбаатар сумын дүн	5	61.7	78.4	98.5	Хангалттай	
Цагааннуур сумын дүн	5	97.7	100.0	99.5	Хангалттай	
Жавхлант сумын дүн	5	100.0	100.0	99.7	Хангалттай	
Нийт дүн	128	81.7	83.8	90.5		